



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ, ЗАСГИЙН ГАЗРААС ОЛГОСОН ВЕКСЕЛИЙН ҮР ДҮН



Төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд тавигдах техникийн хяналт хангалтгүйгээс бүрэн хэрэгжээгүй ажлыг ашиглалтад хүлээн авах, санхүүжилтийг гүйцэтгэсэн ажлын хувь хэмжээнээс илүү олгох зөрчил оршсоор байна.

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харьяа

Сэлэнгэ аймгийн

Аудитын газар

Тэргүүлэх аудитор

Ч.Энхтуяа

Аудитын менежер

Б.Батмөнх

Шинжээч

Э.Эрдэнэзул

2017 оны 04 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70362442
дугаарын утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум, аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд,

Бүлэг 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх?

А. Хуулийн шаардлагад нийцүүлэн төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан уу?

А.1 Төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлого төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн эсэх?

А.2 Хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, үр ашиггүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх?

А.3 Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх?

А.4 Төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл иж бүрэн, хуулийн шаардлага хангасан эсэх?

А.5 Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн, санхүүжих дүнд өөрчлөлт орж хуульд тусгагдсан эсэх?

А.6 Төсвийн тухай хуульд төсөл, арга хэмжээний нэр, эхлэх, дуусах хугацаа байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан эсэх?

А.7 Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө шилжих арга хэмжээнд шаардлагатай санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилж, шат шатны хяналтыг тавьж батлуулсан эсэх?

Б.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан уу?

Б.1 Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, ил тод, шуурхай байдлыг хангасан эсэх?

Б.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны журмыг зөрчсөн, өрсөлдөөнийг хязгаарласан эсэх?

Б.3 Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тайлагнасан эсэх?

Б.4 Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, үр ашиггүй зарцуулсан эсэх?

Б.5 Худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдах, бэлтгэл ажил хангагдсан төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч сонгон шалгаруулсан эсэх?

Б.6 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн эсэх?

В. Гэрээний хэрэгжилт, санхүүжилт үр нөлөөтэй байна уу?

В.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлүүд тодорхойгүй, оновчтой бус, хугацаа хэтэрсэн эсэх?

В.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, бүрэн ашигласан эсэх?

В.3 Төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл дутуу болон хуурамч гүйцэтгэлд санхүүжилт олгосон, талуудын хяналт хангалтгүйгээс зураг төсөвт өөрчлөлт орсон үргүй зардал гаргасан эсэх?

В.4 Төсөл, арга хэмжээний санхүүжих дүн дутуу батлагдсанаас, бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлээгүйгээс арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшилсон эсэх?

В.5 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд тавих талуудын хяналт хангалтгүй байх, захиалагч гэрээ дүгнэж хэрэгжилтийг хангуулсан эсэх?

В.6 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгож ашиглалтад оруулсан эсэх?

В.7 Төсөл, арга хэмжээ нь чанарын болон ашиглалтын шаардлага хангасан эсэх?

Илрүүлсэн зөрчил

Дүгнэлт

Зөвлөмж

Бүлэг 2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх ?

А. Хуулийн шаардлагад нийцүүлэн төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан уу?

А.1 Төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлого төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн эсэх?

А.2 Хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, үр ашиггүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх?

А.3 Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх?

А.4 Төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл иж бүрэн, хуулийн шаардлага хангасан эсэх?

А.5 Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн, санхүүжих дүнд өөрчлөлт орж хуульд тусгагдсан эсэх?

А.6 Төсвийн тухай хуульд төсөл, арга хэмжээний нэр, эхлэх, дуусах хугацаа байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан эсэх?

А.7 Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө шилжих арга хэмжээнд шаардлагатай санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилж, шат шатны хяналтыг тавьж батлуулсан эсэх?

Б.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан уу?

Б.1 Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, ил тод, шуурхай байдлыг хангасан эсэх?

Б.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны журмыг зөрчсөн, өрсөлдөөнийг хязгаарласан эсэх?

Б.3 Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тайлагнасан эсэх?

Б.4 Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, үр ашиггүй зарцуулсан эсэх?

Б.5 Худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдах, бэлтгэл ажил хангагдсан төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч сонгон шалгаруулсан эсэх?

Б.6 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн эсэх?

В. Гэрээний хэрэгжилт, санхүүжилт үр нөлөөтэй байна уу?

В.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлүүд тодорхойгүй, оновчтой бус, хугацаа хэтэрсэн эсэх?

В.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, бүрэн ашигласан эсэх?

В.3 Төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл дутуу болон хуурамч гүйцэтгэлд санхүүжилт олгосон, талуудын хяналт хангалтгүйгээс зураг төсөвт өөрчлөлт орсон үргүй зардал гаргасан эсэх?

В.4 Төсөл, арга хэмжээний санхүүжих дүн дутуу батлагдсанаас, бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлээгүйгээс арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшилсон эсэх?

В.5 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих талуудын хяналт хангалтгүй байх, захиалагч гэрээ дүгнэж хэрэгжилтийг хангуулсан эсэх?

В.6 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгож ашиглалтад оруулсан эсэх?

В.7 Төсөл, арга хэмжээ нь чанарын болон ашиглалтын шаардлага хангасан эсэх?

Илрүүлсэн зөрчил

Дүгнэлт

Зөвлөмж

Бүлэг 3 .Засгийн газраас олгосон векселийн үр дүн

А.4 Векселиэр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ хууль болон Засгийн газрын тогтоолд давхар тусгагдсан эсэх?

Б.3 Векселиэр санхүүжүүлсэн барилга, угсралтын ажлын гүйцэтгэл бодитой эсэх?

Б.7 Векселиэр санхүүжилт авсан гүйцэтгэгч ТЕЗ-тай тооцоо нийлж, магадлашгүй ажил, норм, норматив, зураг төсөв, техник хяналтын зардлыг буцаан төвлөрүүлсэн эсэх?

Илрүүлсэн зөрчил

Дүгнэлт

Зөвлөмж

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХАА	Худалдан авах ажиллагаа
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Сэлэнгэ аймгийн Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн Аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, векселиэр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.*
- *Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.*
- *Векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.*

Хамрах хүрээ:

Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, векселиэр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө, оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох байгууллага, аймаг, орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хүрээнд шалгав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, мэдээ, шаардлагатай бусад баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

2016 оны Төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, Иргэний хууль, Барилгын тухай хууль, дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Үндсэн мэдээлэл:

Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 230.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх эрхийг шилжүүлснээс Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын багцаас 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ, Эрүүл мэндийн сайдын багцаас 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Сэлэнгэ аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай” 15 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төсөл, арга хэмжээг нийт 1,054.2 сая төгрөг байхаар тодотгож баталсан байна.

2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар Сэлэнгэ аймагт 2010 оноос хойш эрх шилжин хэрэгжиж эхэлсэн 10,531.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл арга хэмжээний үлдэгдэл 1,290.6 сая төгрөгийн санхүүжилтийг векселиэр гүйцэтгэхээр баталсан байна.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, шинжээч Э.Эрдэнэзул 2017 оны 2 дугаар сарын 10-наас 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

А.1 Аймгийн 2013-2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх саналыг холбогдох яамдад хүргүүлсэн байна.

1.1 Төсвийн тухай хуулийн 28¹ дугаар зүйлийн 28.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байдаг.

1.2 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээний бүх сумдын иргэд, төр, төсвийн байгууллагуудын удирдлага, ажиллагсадтай уулзалт зохион байгуулж, зайлшгүй хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын талаарх судалгаа, санал, хүсэлтийг сонсон, нэгтгэн дүгнэсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг жил жилийн төлөвлөгөөнд ач холбогдол, ээлж дарааллын дагуу тусгаж, гүйцэтгүүлэх бодлого баримталж, саналыг холбогдох яамдад уламжилсан байна.

1.3 Сэлэнгэ аймгийг 2013-2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар **43,580.7** сая төгрөгийн төсөвт өртөг бүхий **25** төсөл, арга хэмжээний саналыг холбогдох яамдад хүргүүлжээ. /Хавсралт №1-д харуулав /

1.4 Санал хүргүүлсэн 25 төсөл, арга хэмжээний 23,466.8 сая төгрөгийн өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээ нь Сэлэнгэ аймгийг 2013-2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр болон Засаг даргын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан бөгөөд бусад 15 нь даац, норм, норматив хэтэрсэн, хуучирч муудсан, засвар, үйлчилгээ, шинэчлэлт зайлшгүй хийх шаардлагатай барилга угсралт, их засварын ажлууд байна.

1.5 Тухайлбал, Сэлэнгэ аймгийг 2013-2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн 2.5 дахь “Боловсролын хөгжил, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүн”-д “Хүн амын хэтийн төлөв, сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдүүдийн ердийн өсөлтийг харгалзан сургууль, цэцэрлэг, дотуур байрыг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх” гэсэн заалт болон Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд Орхон, Сайхан сумдад тус бүр 100 ортой сургуулийн дотуур байр барих, Зүүнбүрэн суманд сургуулийн өргөтгөлийн барилга, Сүхбаатар сумын Салхит багт 75 ортой цэцэрлэгийн барилга, Хушаат сумын сургуулийн барилгын их засвар гэх мэт нийт 16,961.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл, арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргын 2015 оны 08-р сарын 18-ны өдрийн 1/666 тоот албан бичгээр БСШУЯ-нд хүргүүлсэн байна.

А.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн төсөл, арга хэмжээнээс нэг нь ч батлагдаагүй байна.

¹ Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт

1.6 Холбогдох яамдад санал хүргүүлсэн 25 төсөл, арга хэмжээнээс нэг нь ч 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй бөгөөд аймаг, орон нутгаас явуулсан саналд тусгагдаагүй дараах их засварын ажлууд тусгагдаж, аймгийн Засаг даргад хэрэгжүүлэх эрх нь шилжиж ирсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /сая.төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих
1	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	2016-2016	120.0	120.0
2	2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засвар / Сэлэнгэ, Сүхбаатар сум /	2016-2016	80.0	80.0
3	“Номт хан” өрхийн эмнэлгийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум /	2016-2016	30.0	30.0

А.3 Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдоогүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлж байна.

1.7 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн барилга угсралтын 17 ажлын газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлээгүй буюу зөвшөөрөл нь олгогдоогүй байна.

1.8 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан 3 төсөл, арга хэмжээ нь барилга угсралтын бус их засварын ажлууд тул газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл авах шаардлагагүй байсан байна.

А.4 Зураг, төсөв нь хийгдээгүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгадаг зөрчил оршсоор байна.

1.9 Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан байдаг.

1.10 Хөрөнгө, санхүүжилтийн хомсдол буюу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлж буй төсөл, арга хэмжээ нь төсөвт тусгагдаж, батлагдах эсэх нь тодорхой бус байдаг гэдэг шалтгаанаар санал хүргүүлсэн 25 ажлын ТЭЗҮ, зураг, төсөв хийгдээгүй байна.

1.11 Дээрх шалтгааны улмаас Номт хан өрхийн эмнэлгийн засварын ажлын зураг төсвийн гэрээг 2016 оны 10-р сарын 03-ны өдөр, Сайхан сумын сургуулийн засварын ажлын зураг, төсвийн гэрээг 2016 оны 03-р сарын 30-ны өдөр, Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн сантехник, хана, хүчитгэл засварын ажлын зураг, төсвийн гэрээг 2016 оны 09 сарын 05-ны өдөр гэх мэтчилэн 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, хэрэгжсэн бүх ажлуудын зураг, төсвийг төлөвлөхийн өмнө бус батлагдсан төсөвт өртөгт нь багтаан, батлагдсаны дараа гүйцэтгүүлсэн байна.

А.5 Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдээгүй, санхүүжих дүнд өөрчлөлт ороогүй байна.

1.12 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаж, батлагдсан Номт хан өрхийн эмнэлгийн засвар, Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн сантехник, хана, хүчитгэл засвар, Сайхан сумын сургуулийн их засварын ажлуудын төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй байна. / Хавсралт №2- д харуулав /

1.13 2016 оны Төсвийн тухай хуульд тусгагдаж, батлагдсан бөгөөд өмнөх онуудаас он дамжиж, Сэлэнгэ аймгийн Засаг даргад эрх шилжсэн 9 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнд өөрчлөлт ороогүй байна. / Хавсралт №3- д харуулав /

А.6 Төсөл, арга хэмжээний нэр, эхлэх, дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдаагүй байна.

1.14 2016 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 3 их засварын ажил болон өмнөх онуудаас он дамжин, хэрэгжиж буй Сэлэнгэ аймагт эрх шилжсэн 9 төсөл, арга хэмжээний эхлэх, дуусах хугацаа, байршил болон ангилал нь 2016 оны Төсвийн тухай хуульд зөрүүтэй тусгагдаагүй байна. / Хавсралт №2,3-аас харах /

А.7 Он дамжин хэрэгжиж буй шилжих арга хэмжээний шаардлагатай санхүүжилтийг векселиэр санхүүжүүлэхээр баталсан байна.

1.15 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар Сэлэнгэ аймагт эрх шилжин хэрэгжиж буй 10,531.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 шилжих арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 1,290.6 сая төгрөгийг векселиэр санхүүжүүлэхээр баталсан байна. / Хавсралт №3-д харуулав /

Б.1 Үнэлгээний хороо, ажлын хэсгийг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

1.16 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн, аймгийн Засаг даргад эрх шилсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2016 оны 05 сарын 16-ны өдөр анх баталсан бөгөөд 2016 оны 11-р сарын 15-ны өдөр дараах жагсаалтаар тодотгож баталсныг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2 /сая.төгрөг/

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам
1	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	120.0	120.0	Нээлттэй тендер шалгаруулалт
2	2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засвар /Сэлэнгэ, Сүхбаатар/	80.0	80.0	Харьцуулалтын арга
3	“Номт хан” өрхийн эмнэлгийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар/	30.0	30.0	Харьцуулалтын арга

1.17 ТБОНӨХБАҮХАТ хууль, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах” журмын дагуу аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар дээрх их

засварын ажлуудын үнэлгээний хороо, ажлын хэсгийг тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

1.18 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо, ажлын хэсэгт аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, ГХБХБГ-ын мэргэжилтнүүд, иргэний төлөөллөөс гадна өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу ашиглагч байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.

1.19 ТБОНӨХБАҮХАТ хууль, Засгийн Газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн журмыг баримтлан Сайхан сумын сургуулийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, бусад 2 ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.

1.20 Сайхан сумын сургуулийн барилгын их засвар, Номт хан өрхийн эмнэлгийн их засварын ажлын худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр, Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засварын ажлын худалдан авах ажиллагааг цаасан хэлбэрээр зохион байгуулсан байна.

1.21 Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг Зууны мэдээ сонин, Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.e-procurement.mof.gov.mn, Сэлэнгэ аймгийн www.selenge.gov.mn цахим хуудсанд тус тус мэдээлсэн байна.

Б.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөн ажилласан байна.

1.22 Үнэлгээний хороо, ажлын хэсэг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн дээрх 3 их засварын ажлын худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмуудыг хангахаар зохион байгуулсан байна.

1.23 Үнэлгээний хороо, ажлын хэсгүүд нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлийн хүрээнд тендер шалгаруулалтад оролцогч компаниудын ерөнхий нөхцөл, санхүү, техникийн чадавхи, туршлагыг тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийн дагуу харьцуулан үнэлж, шаардлагад нийцсэн, хамгийн бага үнийн санал ирүүлсэн компанийг сонгон шалгаруулсан байна.

1.24 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр дараах компаниудыг сонгон шалгаруулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 /сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Гүйцэтгэгчийн нэр
1	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	120.0	98.6	“Нью гранд цамхаг” ХХК
2	2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засвар /Сэлэнгэ, Сүхбаатар/	80.0	80.0	“СДММ” ХХК
3	“Номт хан” өрхийн эмнэлгийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар/	30.0	29.0	“Есөн хэлхээ” ХХК

1.25 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28.3 дахь “ шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна”, 28.7.4 дэх “ хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзнэ” гэсэн заалтын дагуу шаардлагад нийцсэн компаниуд үнийн саналаар уралдаж байгаа нь төсөвт өртгийг хэт багасгах, улмаар санхүүжилт хүрэлцэхгүй болж, төлөвлөсөн ажил ашиглалтад орохгүй удаашрах нэг нөхцөл болж байна.

1.26 Тухайлбал 120.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Сайхан сумын сургуулийн их засварын ажлын тендерт орсон “Нью гранд цамхаг” компани нь 98.6 сая төгрөг буюу батлагдсан төсөвт өртгийг 17.8 хувиар бууруулсан үнийн саналаар гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулан, гэрээний үнийн 80.0 хувь болох 79,8 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч санхүүжилт хүрээлцээгүй гэдэг шалтгаанаар уг ажлыг өнөөг хүртэл ашиглалтад хүлээлгэн өгөөгүй, зогсоосон байна.

1.27 Худалдан авах үйл ажиллагаа, сонгон шалгаруулалттай холбоотой ямар нэгэн гомдол, санал гараагүй байна.

Б.3 Улсын төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авалтын тайланг хуулийн хугацаанд гаргаж, хүргүүлсэн байна.

1.28 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 24.3-д “Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно”, 24.5-д “Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна” гэж тус тус заасны дагуу тайлант онд хэрэгжих төсөл, арга хэмжээ тус бүрийн худалдан авах ажиллагааг дунджаар 13-52 хоногийн хугацаанд зохион байгуулсан байна.

1.29 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49² дүгээр зүйлийн 49.1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэж заасны дагуу төсөл, арга хэмжээ бүрээр хавтаст хэрэг бүрдүүлэн, архивын нэгж болгон хадгалсан байна.

1.30 Мөн хуулийн 49.5-д “Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана”, Сангийн сайдын 2012 оны 264 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1-д “Захиалагч тухайн жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тухай бичмэл тайланг маягт 2-т заасан зааврын дагуу бэлтгэж, түүнд маягт 3-ын дагуу бэлтгэсэн ерөнхий тайланг хавсаргана” гэж тус тус заасны дагуу тайлант оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авалтын тайланг маягтын дагуу бэлтгэж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Б.4 Худалдан авах ажиллагаанаас аймгийн түвшинд хэмнэлт үүсээгүй байна.

1.31 2016 онд улсын төсвөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны үр дүнд дараах хэмнэлтүүд гарсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

² Худалдан авах ажиллагааг тайлагнах

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний үнэ	Хэмнэлт
1	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	120.0	98.6	21.4
2	2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засвар /Сэлэнгэ, Сүхбаатар/	80.0	80.0	-
3	“Номт хан” өрхийн эмнэлгийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар/	30.0	29.0	1.0

1.32 Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон гэрээний үнийн зөрүүгээр дээр дурдсан хэмжээний хэмнэлт үүссэн харагдаж байгаа боловч хэрэгжүүлэх эрх нь аймагт шилжсэн ажлуудын санхүүжилтийг төсөвт өртгөөр нь бус ажлын гүйцэтгэлийн хувь, хэмжээтэй нь дүйцүүлэн холбогдох яамдаас аймагт шилжүүлснийг гүйцэтгэгч компанид дамжуулан олгож байгаа учир аймгийн түвшинд хэмнэлт гарах боломжгүй байна.

Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрхийг хугацаа алдаж шилжүүлсэн байна.

1.33 БСШУЯ-ны сайдын 2016 оны 03-р сарын 14-ний өдрийн №1/2132 дугаар албан бичгээр Сайхан сумын сургуулийн барилгын их засварын ажлын, 10-р сарын 20-ны өдрийн №А/81 дүгээр тушаалаар Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засварын ажлын, Эрүүл мэндийн сайдын 2016 оны 09-р сарын 15-ны өдрийн №А/44 дүгээр тушаалаар Сүхбаатар сумын Номт хан өрхийн эмнэлгийн их засварын ажлын эрхийг Сэлэнгэ аймгийн Засаг даргад тус тус шилжүүлсэн байна.

1.34 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ажлуудын эрхийг тайлант оны сүүлээр, хугацаа алдаж шилжүүлсэн нь худалдан авах ажиллагаа оройтож зохион байгуулагдах, улмаар тухайн ажил гэрээт хугацаанд хэрэгжиж дуусахгүй, он дамжих эрсдэлийг дагуулж байна.

1.35 Тухайлбал, Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засварын ажлын гэрээг 2016 оны 11 сарын 23-ны өдөр, Номт хан өрхийн эмнэлгийн их засварын ажлын гэрээг 2016 оны 10-р сарын 26-ны өдөр байгуулж, ажил эхлүүлснээс цэцэрлэгийн гадна сантехникийн ажлыг тайлант онд багтаан гүйцэтгэх боломжгүй болсон байна.

Б.6 Төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчлөөгүй байна.

1.36 БСШУЯ, Эрүүл мэндийн яамнаас аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн дээрх 3 их засварын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа, төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчлөөгүй байна.

В.1 Сайхан сумын сургуулийн барилгын их засварын ажил гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй байна.

1.37 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт хэрэгжих 3 их засварын ажлын гэрээг захиалагч болох аймгийн ЗДТГ болон гүйцэтгэгч компанийн хооронд байгуулсан бөгөөд уг гэрээнд ТБОНӨБАҮХА тухай хуулийн 40.2, 40.3-т заасан нөхцлүүдийг тусгасан боловч Сайхан сумын сургуулийн засварын ажлыг гүйцэтгэгч “Нью гранд цамхаг” компанитай 2016 оны 04 сарын 08-ны өдөр байгуулсан СЭ-ХААА-25/2016 дугаар гэрээнд захиалагчийн хяналтын талаар тусгаагүй байна.

1.38 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 -2016 он дамжин хэрэгжсэн Мандал сумын нэгдсэн эмнэлгийн их засварын ажлаас гадна 2016 онд хэрэгжсэн дараах ажлуудыг улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Ашиглалтад орсон огноо	Улсын комиссын	
			Актын дугаар	Комиссын бүрэлдэхүүн
1	2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засвар / Сэлэнгэ, Сүхбаатар сум /	2016.12.21	СЭ-ХААА-64/2016	Дарга, 7 гишүүн нийт 8
2	“Номт хан” өрхийн эмнэлгийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2016.11.17	50	Дарга, 6 гишүүн нийт 7
3	Нэгдсэн эмнэлгийн засвар /Сэлэнгэ, Мандал сум/	2016.12.23	ЭМСЯ-2015/XVI-1.3-2-ГС	Дарга, 7 гишүүн нийт 8

1.39 Харин Сайхан сумын сургуулийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Нью гранд цамхаг” ХХК нь тус ажлыг 2016 оны 07-р сарын 28-наас 08-р сарын 28-ны хооронд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч өнөөг хүртэл ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байна.

1.40 Дээрх их засварын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөх гэрээний хугацаа хэтрээд даруй 7 сар болж болсон бөгөөд гэрээт ажил дутуу хийгдэж, зогссон байхад захиалагчийн зүгээс гүйцэтгэгч компанитай хариуцлага тооцоогүй байна.

В.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.41 Хэрэгжүүлэх эрх нь аймагт шилжсэн ажлуудын санхүүжилтийг төсөвт өртгөөр нь бус ажлын гүйцэтгэлийн хувь, хэмжээтэй нь дүйцүүлэн холбогдох яамдаас аймагт шилжүүлснийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс гүйцэтгэгч компанид дамжуулан олгож байна.

1.42 2016 оны Төсвийн тухай хуульд тусгагдаж, Сэлэнгэ аймгийн Засаг даргад эрх шилжин хэрэгжсэн, төсөл арга хэмжээний санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Яамнаас аймагт олгосон санхүүжилт	Аймгийн CTCX-аас санхүүжүүлсэн дүн
1	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	120.0	98.6	79.7	79.7
2	2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	80.0	80.0	80.0	76.0
3	Номт хан өрхийн эмнэлгийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	30.0	29.0	28.5	28.5
4	Нэгдсэн эмнэлгийн засвар /Сэлэнгэ, Мандал сум/	-	368.0	368.0	293.1
	НИЙТ	230.0	575.6	556.2	477.3

1.43 Номт хан өрхийн эмнэлгийн болон Сайхан сумын сургуулийн их засварын ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээтэй нь уялдуулан холбогдох яамдаас шилжүүлсэн санхүүжилтийг гүйцэтгэгч компаниудад бүрэн олгосон байна.

1.44 Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засварын гадна сантехникийн ажлыг хүйтний улиралд гүйцэтгэх боломжгүй болсон тул уг ажлыг дараа оны дулааны улиралд гүйцэтгэхээр тохиролцож, хийгдээгүй ажлын санхүүжилт 4.0 сая төгрөгийг, өмнөх оноос он дамжсан Мандал сумын нэгдсэн эмнэлгийн засварын ажлын гүйцэтгэгч “Эм Ти Эм Жи ХХК” нь чанарын шаардлага хангахгүй хаалга суулгасан гэж үзэж, 74.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авч үлдэн, оны эцэст аймгийн төрийн сан дахь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн 130051304 дугаар дансанд төвлөрүүлсэн байна.

В.3 Гэрээний дагуу санхүүжилтийг олгоогүй байна.

1.45 Гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй 120.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Сайхан сумын сургуулийн барилгын их засварын ажлын гүйцэтгэлийг захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-аас 68.0 хувиар үнэлсэн байхад 80.0 хувийн санхүүжилт буюу 10.6 сая төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6³, гүйцэтгэгч “Нью гранд цамхаг” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний 48 дахь “Урьдчилгаа төлбөр олгохгүй, ажлын гүйцэтгэл 40 хувь хүрэхэд 1 дэх санхүүжилт гэрээний дүнгийн 40 хувийн санхүүжилт, ажлын гүйцэтгэл 80 хувьд хүрэхэд 2 дахь санхүүжилт гэрээний дүнгийн 40 хувийн санхүүжилт олгож, ажлыг бүрэн хүлээлгэн өгсний дараа сүүлийн үлдэгдэл санхүүжилт 20 хувийг олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

³ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх

1.46 Сайхан сумын сургуулийн засварын ажлын батлагдсан төсөв /120.0 сая/ болон гэрээний үнийн /98.6 сая/ зөрүү 21.4 сая төгрөгөөр нэмэлт ажлын төсөв хийлгэн, / хаалга цонх, дотор засал, шал, дотор цэвэр бохир усны ажил багтсан / гүйцэтгүүлэх гэрээ байгуулаагүй байхад холбогдох яамтай тохиролцсон гэх шалтгаанаар гүйцэтгэгч “Нью гранд цамхаг” ХХК-иар нэмэлт ажлын 40.0 хувийг гүйцэтгүүлсэн боловч санхүүжилтийг олгоогүй байна.

В.4 Төсөл, арга хэмжээний санхүүжилтээс шалтгаалан хэрэгжих хугацаа хойшилсон зөрчил гараагүй байна.

1.47 2016 оны Төсвийн тухай хуульд тусгагдан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж, тус аймагт эрх шилжсэн 3 төсөл, арга хэмжээний санхүүжилт дутуу батлагдсан, санхүүжилтийг хугацаанд нь олгоогүй зэрэг санхүүжилттэй холбоотой шалтгааны улмаас хэрэгжих хугацаа хойшилсон зөрчил гараагүй бөгөөд Сайхан сумын барилгын их засвар, Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн засварын ажлууд гэрээт хугацаанд бүрэн гүйцэтгэгдээгүй, Мандал сумын нэгдсэн эмнэлгийн засварын ажлын зарим хэсэг нь чанарын шаардлага хангаагүй гэх үндэслэлээр холбогдох санхүүжилтийг олгоогүй байна.

В.5 Гэрээт ажлуудын гүйцэтгэлд захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна.

1.48 Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэн, хэрэгжсэн 4 их засварын ажлын захиалагчийн хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ хэрэгжүүлж, Номт хан өрхийн эмнэлгийн их засварын ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан байна.

1.49 Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засварын гадна сантехникийн засвар хийгдээгүй, Мандал сумын нэгдсэн эмнэлгийн дотор хаалгууд чанарын шаардлага хангаагүй байхад тус тус улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авч, дутуу ажлыг дулааны улиралд гүйцэтгүүлэхээр тохиролцсон байна.

1.50 Сайхан сумын сургуулийн барилгын их засварын ажил нь гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй өнөөг хүрсэн байхад захиалагчийн зүгээс гэрээг дүгнэж, алданги тооцоогүй, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аваагүй байна.

В.6 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг улсын комиссоор ашиглалтад хүлээн аваагүй болон улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгосон зөрчил гараагүй байна.

1.51 Тайлант хугацаанд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн аваагүй зөрчил гараагүй бөгөөд харин бүрэн хэрэгжиж дуусаагүй болон чанарын шаардлага хангаагүй дараах төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд:

- Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн гадна сантехникийн засварын ажил хийгдээгүй байхад,
- Мандал сумын нэгдсэн эмнэлгийн дотор хаалгууд чанарын шаардлага хангаагүй гэж үзсэн боловч тус тус хүлээн авсан байна.


1.52 Төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан улсын комиссын актыг үндэслэн холбогдох санхүүжилтийг олгосон бөгөөд ашиглалтад хүлээн авсан боловч дутуу

хийгдсэн дээрх 2 засварын ажлын санхүүжилтийг аймгийн төрийн сан дахь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд авч үлдсэн байна.

В.7 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь чанарын болон ашиглалтын шаардлагыг бүрэн хангахгүй зөрчил оршсоор байна.

1.53 Бид гүйцэтгэлийн аудитын явцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, ашиглалтыг газар дээр нь тулган баталгаажуулахад дараах зөрчил оршиж байлаа. Үүнд:

- *Мандал сумын нэгдсэн эмнэлгийн удирдлага, эмч, ажиллагсдаас ярилцлага авахад “уг ажил удаашралтай хийгдэж, эмнэлгийн ажил хэвийн явагдахад удаан хугацаагаар тоо шороо бужигнах, эрүүл ахуйн нөхцөл алдагдах зэрэг хүндрэл учирч байсан бөгөөд хаалга, цонх, шалнууд хэврэг материалаар хийгдсэнээс олон хүний гарын ая даахгүй, сайн хаагдахгүй байх, салхи сийгэх, салж унах зэрэг байдал гарч байна” гэж байлаа.*



*Мандал сумын нэгдсэн эмнэлэгт хийгдсэн засварын хэсэг
/ 2017-03-28 /*

- *Сүхбаатар сумын Номт хан өрхийн эмнэлгийн засварын ажлын хүрээнд шинээр сольсон паркетан шал нь сайн шахагдаагүйгээс шал хооронд их хэмжээний зай, завсар үүссэн байна.*

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ:

Аудитаар 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймагт төлөвлөж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 98.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий Сайхан сумын сургуулийн их засварын ажлын гүйцэтгэл 68.0 хувь гэж үнэлэгдсэн бөгөөд дутуу хийгдсэн ажлын өртөг 31.5 сая төгрөг,
- Сайхан сумын сургуулийн барилгын их засварын ажлын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээс илүү олгосон 12.7 сая төгрөг / Ажлын гүйцэтгэл 68.0 хувьтай байхад 80.0 хувийн санхүүжилтийг олгосон /

- Нэмэлт ажлын гэрээ байгуулаагүй атал Сайхан сумын сургуулийн засварын худалдан авах үйл ажиллагааны хэмнэлт / *төсөвт өртөг болон гэрээний үнийн зөрүү* / 21.4 сая төгрөгөөр хаалга, цонх солих, ариун цэврийн өрөөний засвар зэрэг ажлуудыг хийлгэж эхэлсэн.
- Бүрэн хэрэгжиж дуусаагүй болон чанарын шаардлага хангаагүй ажлыг улсын комиссын актаар хүлээн авч холбогдох санхүүжилтийг аймгийн төрийн сан дахь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн 78.9 сая төгрөг / *Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн гадна сантехник засвар-4.0 сая төгрөг, Мандал сумын нэгдсэн эмнэлгийн засвар чанарын шаардлага хангаагүй -74.9 сая төгрөг* / зэрэг нийт **144.5 сая** төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Аймгийг 2013-2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр болон Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх саналыг холбогдох яамдад хүргүүлсэн байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн 25 төсөл, арга хэмжээнээс нэг нь ч батлагдаагүй байна.
- Зураг, төсөв нь хийгдэж батлагдаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.
- Он дамжин хэрэгжиж буй, шилжих 9 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг векселиэр санхүүжүүлэхээр баталсан байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эрхийг хугацаа алдаж шилжүүлсэн бөгөөд гүйцэтгэгчийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулсан байна.
- 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, аймгийн Засаг даргад эрх нь шилжсэн төсөл, арга хэмжээний 66.7 хувь нь хэрэгжиж, 33.3 хувь нь гэрээт хугацаанд ашиглалтад ороогүй байна.
- Гэрээт ажлуудын гүйцэтгэлд захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй бөгөөд ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээнээс илүү санхүүжилт олгосон байна.
- Ажил бүрэн гүйцэтгэж дуусаагүй буюу чанарын шаардлага хангаагүй ажлуудыг ашиглалтад хүлээн авч, холбогдох санхүүжилтийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд авч үлдсэн байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээ чанарын болон ашиглалтын шаардлагыг хангахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргил, ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа нарт:

- Сайхан сумын сургуулийн засварын ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгарч, уг ажлыг хэрэгжүүлж буй “Нью гранд цамхаг” компанитай байгуулсан гэрээг дүгнэж, гэрээт ажлыг бүрэн гүйцэтгүүлэх.
- Хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд тавих техникийн хяналтыг сайжруулах, гэрээт ажлаа бүрэн гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авахгүй байх.
- Улсын комиссын актаар хүлээн авсан боловч бүрэн хийгдээгүй Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн гадна сантехник засварын ажлыг гүйцэтгүүлэх, Мандал сумын нэгдсэн эмнэлгийн чанарын шаардлага хангахгүй хаалгануудыг солиулах арга хэмжээ авах.
- Нэмэлт ажлын гэрээ байгуулалгүйгээр ажил эхлүүлдэг зөрчлийг таслан зогсоож, гэрээ байгуулсны үндсэн дээр нэмэлт ажлыг гүйцэтгүүлэх.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга М.Нарантуяа –д :

- Ажлын гүйцэтгэлийн хувь, хэмжээнээс илүү санхүүжилт олгох зөрчлийг таслан зогсоож, ажил гүйцэтгүүлэх гэрээнд заасан хувь хэмжээний дагуу санхүүжилт олгож байх.
- Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн гадна сантехник засварын ажлыг бүрэн гүйцэтгэсний дараа болон Мандал сумын нэгдсэн эмнэлгийн чанарын шаардлага хангахгүй хаалгануудыг солиулсны дараа хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн 74.9 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгох.

БҮЛЭГ 2

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ, ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖСЭН ЭСЭХ

А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, цаг үеийн шаардлагад үндэслэн боловсруулсан байна.

2.1 Аймгийн ИТХ-ын 2015 оны 12-р сарын 04-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн 2016 оны төсөв батлах тухай” 74 дүгээр тогтоолд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх төсөл, арга хэмжээ батлагдаагүй бөгөөд төсвийн жилийн явцад төсөвт 3 удаа тодотгол хийж, өмнөх оноос шилжих 7, шинээр эхлэх 29 зэрэг нийт 1,054.2 сая / нэг тэрбум тавин дөрвөн сая хоёр зуун мянга / төгрөгийн өртөг бүхий 36 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна. /Хавсралт №4- д харуулав /

2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа сумдаас ирүүлсэн санал болон аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх бодлого баримтлан, хөрөнгө, санхүүгийн нөөц боломж, ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг харгалзан эрэмбэлсэн байна.

А.2 Автомашин, тоног төхөөрөмж худалдан авах, хөшөө дурсгал босгох зэрэг арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.3 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 2.2 хувь буюу 23.4 сая төгрөгийг улсын төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардал эзэлж байна. Үүнд:

- *Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторид химийн урвалж бодис худалдан авахад 6.0 сая төгрөг,*
- *Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антен худалдан авахад 8.4 сая төгрөг,*
- *Аймгийн Прокурорын газарт тавилга худалдан авахад 9.0 сая төгрөг зэрэг болно.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ”, 6.6.6 дахь “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэн тэргүүний ач холбогдолтой бус автомашин, тоног төхөөрөмж худалдан авах, хөшөө дурсгал барих, төрийн албан хаагч болон гүйцэтгэгч компанийн буруутай үйлдлээс ашиглалтад ороогүй барилга угсралтын ажлыг санхүүжүүлэх чиглэлээр болон ОНХС-гийн эх үүсвэрээр хийгдэж болох дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- *Бороо гоулд компанийн хандивын хөрөнгөөр Баянгол суманд 2013 онд баригдаж эхэлсэн Хүүхэд хөгжлийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулаагүйгээс 357.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч нурж унасан барилгыг 2016-2017 онуудад нийт 619.2 сая төгрөгөөр санхүүжүүлэх, үүнээс 2016 онд 20.0 сая төгрөг олгох,*
- *Хөшөө барихад 5.0 сая төгрөг,*
- *Аймгийн ЗДТГ-т үйлчилгээний “микробус” автомашин худалдан авах 45.0 сая төгрөг,*
- *Сэлэнгийн долгио чуулгын тоног, төхөөрөмж худалдан авах 38.5 сая төгрөг,*
- *Рашаант тосгоны 2-р сургуулийн тоног төхөөрөмж шинэчлэлт 26.6 сая төгрөг,*
- *Сант сумын сургуулийн зааланд тоног төхөөрөмж худалдан авах 20.0 сая төгрөг,*
- *Цагааннуур сумын сургуулийн гал тогоонд тоног төхөөрөмж авах 20.0 сая төгрөг,*
- *Жавхлант сумын соёлын төвд хөгжим хэрэгсэл, тоног төхөөрөмж авах 20.0 сая төгрөг зэрэг болно.*

А.3 Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл аваагүй төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвөөс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зөрчил гараагүй байна.

2.5 2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр эхлэх барилга угсралтын бус өмнөх оноос шилжсэн төсөл, арга хэмжээ, хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах, их засварын ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн учир газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл авах шаардлагагүй байсан байна.

А.4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвт өртгийг урьдчилан тооцоогүй их засварын болон тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг тусгаж, баталсан байна.

2.6 Төсвийн тухай хуулийн 29-р зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалтын дагуу шинээр эхлэх 8 төсөл арга хэмжээний зураг, төсвийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдахын өмнө хийсэн бол тоног төхөөрөмж худалдан авах, их засварын зэрэг 21 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг урьдчилан тооцолгүйгээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна. / Хавсралт № 5-д харуулав /

А.5 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт ороогүй байна.

2.7 2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос шилжин хэрэгжиж буй 7 төсөл, арга хэмжээнд 395.5 сая төгрөгийн, шинээр эхлэх нийт 1,267.1 сая төгрөгийн өртөг бүхий 29 төсөл, арга хэмжээнд 658.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор аймгийн ИТХ-аас баталсан байна.

2.8 Дээрх төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт ороогүй байна.

А.6 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний нэр, эхлэх, дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдаагүй байна.

2.9 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өмнөх оноос шилжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын 7, шинээр эхлэх 29 төсөл арга хэмжээний нэр, эхлэх, дуусах хугацаа байршил болон ангилал зөрүүтэй тусгагдаагүй байна.

А.7 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шилжих арга хэмжээнд шаардлагатай санхүүгийн нөөцийг хуваарилж, баталсан байна.

2.10 Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар “Сэлэнгэ аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор өмнөх онд худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч огт хэрэгжээгүй, ажил нь эхэлсэн боловч бүрэн дуусаагүй, бүрэн хийгдэж дууссан боловч санхүүжилт дутуу олгогдсон зэрэг нийт 7 төсөл, арга хэмжээнд 395.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

2.11 Ингэснээр өмнөх онд бүрэн хэрэгжсэн 4 ажлын дутуу санхүүжилт 248.5 сая төгрөгийг шилжүүлж, он дамжин хэрэгжсэн 3 ажлыг 2016 онд бүрэн ашиглалтад оруулан, 134.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, ашиглалтад хүлээн авсан боловч чанарын эрсдэлийг шалгах шаардлагатай 1 төсөл арга хэмжээний санхүүжилтээс 12.7 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд авч үлдсэн байна.

Б.1 Ажлын хэсгийг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

2.12 Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар “Сэлэнгэ аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор шинээр 29 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд үүнээс 2016 онд хэрэгжсэн 14 төсөл,

арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. / 15 төсөл арга хэмжээ нь тайлант онд хэрэгжээгүй, дараа онд шилжсэн байна/

2.13 ТБОНӨХБАҮХАТ хууль болон ЗГ-ын 2013 оны 68 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн журмыг баримтлан 7 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан бол шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлэх 4 ажлын эрхийг холбогдох байгууллагуудад шилжүүлж, 3 ажлыг захиалагч аймгийн ЗДТГ шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна. /Хавсралт №6 -д харуулав./

2.14 Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 7 төсөл арга хэмжээний ажлын хэсгийг холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнд нь аймгийн болон сумдын ЗДТГ, Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүд, ашиглагч байгууллагын төлөөллийг оролцуулсан байна. Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7 /сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байгууллага
1	Бүх сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ /application/ үүсгэх	21.0	Аймгийн Орон нутгийн өмчийн газар
2	Сэлэнгийн долгио чуулгад тоног төхөөрөмжийн шинэчлэлт	38.5	Аймгийн Орон нутгийн өмчийн газар
3	Аймгийн ЗДТГ-т үйлчилгээний микробус автомашин авах	45.0	Аймгийн Орон нутгийн өмчийн газар
4	Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор заслын ажил	73.3	Аймгийн ЗДТГ
5	Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах	73.5	Мандал сумын Засаг дарга
6	Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих	35.0	Баруунбүрэн сумын Засаг дарга
7	Жавхлант сумын сургуулийн гал тогооны засвар	15.0	Жавхлант сумын Засаг дарга

2.15 Харьцуулалтын аргыг хэрэглэхдээ ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашиг, хэмнэлттэй байх зарчмыг баримтлан, тус бүр 3-аас доошгүй аж ахуйн нэгжид үнийн санал хүргүүлэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Б.2 Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.

2.16 Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан дээрх 7 төсөл, арга хэмжээнээс “сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ /application/ үүсгэх” - төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр, бусад 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цаасан хэлбэрээр зохион байгуулсан байна.

2.17 Аудитын явцад төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үйл ажиллагаанд тулган баталгаажуулалт хийхэд дараах зөрчил оршиж байлаа. Үүнд:

- 73.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор заслын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулалгүй, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтэн нарын 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.
- Ажлын хэсгийн 09-р сарын 18-ны өдрийн хурлаар уг ажлын гүйцэтгэгчээр “Талхун арал” ХХК-ийг шалгаруулахдаа Хаан банкнаас 2016 оны 04-р сарын 21-ний өдөр, Хас банкнаас 2016 оны 07-р сарын 26-ны өдөр авсан өр төлбөргүй талаарх тодорхойлолтууд, аймгийн ШШГА-ны 2016 оны 07-р сарын 25-ны өдрийн /30 хоног хүчинтэй гэсэн/ тодорхойлолтыг үндэслэсэн нь хугацааны хувьд шаардлага хангахгүй гэж үзэж байна. Гүйцэтгэгчээр шалгарсан “Талхун-арал” компани нь 2012 онд Бороо гоулд компанийн хөрөнгө оруулалтаар Баянгол суманд баригдах Хүүхэд хөгжлийн төвийн барилгын гүйцэтгэгчээр ажиллаж 357.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс өнөөг хүртэл ашиглалтад хүлээлгэн өгөөгүйгээр барахгүй угсралт хийгдсэн дээвэр нь нурж унасан бөгөөд өмнөх хөрөнгө оруулалтын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөөгүй, төсөвт их хэмжээний хохирол учруулсан компанийг дахин гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан нь холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн гэж үзэж байна.



- Мандал сумын Засаг даргад эрх шилжүүлсэн 73.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах ажлын гүйцэтгэгчээр Эрчим хүчний яамны ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан “Буйлдмастер” ХХК-г сонгон шалгаруулсан байна.

2.18 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлуудын худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол гараагүй байна.

Б.3 Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тайлагнасан байна.

2.19 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д “Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна”, 33 дугаар зүйлийн 33.3-д “Энэ хуулийн 33.2.1-д заасан үнийн санал ирүүлэх хугацааг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтооно” гэж заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, нэг төсөл, арга хэмжээнд дунджаар 8-32 хоног зарцуулсан байна.

2.20 Мөн хуулийн 49⁴ дүгээр зүйлийн 49.1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэж заасны дагуу харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан худалдан авах ажиллагаа бүрээр хавтаст хэрэг үүсгэн архивын нэгж үүсгэн, хадгалсан байна.

2.21 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.5, Сангийн сайдын 2012 оны 264 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1 дахь заалтуудын дагуу тайлант оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авалтын тайланг маягтын дагуу бэлтгэж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Б.4 Худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтийг ямар нэг зориулалтаар зарцуулаагүй байна.

2.22 2016 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 14 төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагаанаас нийт 7.8 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. / Хавсралт №7-д харуулав /

2.23 Хэдийгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагаанаас нийт 7.8 сая төгрөгийн хэмнэлт бий болсон боловч санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд тохируулан шилжүүлж, үүссэн хэмнэлтийг ямар нэг зориулалтаар зарцуулаагүй байна.

Б.5 Зарим, төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдсан байна.

2.24 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 45⁵ дугаар зүйлийн 45.6-д “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/283 дугаар захирамжаар 147.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг сумдын Засаг дарга нарт шилжүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8 /сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Эрх хүлээн авсан газар
1	Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах	73.5	Мандал сумын Засаг дарга
2	Шаамар сумын ахмадын өргөөнд халаалт тавих	6.0	Шаамар сумын Засаг дарга
3	Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дэр байрнуудад халаалт тавих	35.0	Баруунбүрэн сумын Засаг дарга
4	Орхонтуул сумын халаалтын зуухны засвар	8.0	Орхонтуул сумын Засаг дарга
5	Жавхлант сумын сургуулийн гал тогооны засвар	15.0	Жавхлант сумын Засаг дарга

⁴ Худалдан авах ажиллагааг тайлагнах

⁵ Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулах

6	Шаамар сумын цэцэрлэгт цэвэр усны шугам татах, гал тогооны тоног төхөөрөмж авах	10.0	Шаамар сумын Засаг дарга
---	---	------	--------------------------

2.25 73.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах, 8.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Орхонтуул сумын халаалтын зуухны засварын, 35.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих ажлуудын эрхийг хүйтний улирал эхлэх үетэй зэрэгцэн шилжүүлсэн байгаа нь худалдан авах ажиллагаа оройтож зохион байгуулагдах, улмаар төсөл, арга хэмжээ гэрээт хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Б.6 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчлөөгүй байна.

2.26 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлэхээр баталсан 29 төсөл, арга хэмжээнээс 14 ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, хэрэгжсэн бөгөөд эдгээр төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчлөөгүй байна.

В.1 Нийт төлөвлөсөн ажлын 92.8 хувь нь гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэн байна.

2.27 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд шинээр эхлэх 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрх бүхий албан тушаалтны зүгээс гүйцэтгэгч этгээдүүдтэй байгуулсан 13 гэрээнд ТБОНӨБАҮХА тухай хуулийн 40.2, 40.3-т заасан нөхцлүүдийг тусгасан бөгөөд Орхонтуул сумын “Халаалтын зуухны засвар”-ын ажлыг гүйцэтгэгч “Тулга төгс” компанитай 2016 оны 09 сарын 25-ны өдөр байгуулсан гэрээнд техникийн хяналтын талаар тусгагдаагүй байна.

2.28 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжсэн нийт 14 төсөл, арга хэмжээний 12 нь гэрээт хугацаандаа ашиглалтад орсон байна. /Хавсралт №8 –д харуулав /

2.29 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 21.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Бүх сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ /application/ үүсгэх” ажлыг 2016 оны 05 дугаар сарын 20-ноос 06-р сарын 20-ны хооронд гүйцэтгүүлэхээр “Тауэрсофт” ХХК-тай 2016 оны 05-р сарын 20-ны өдөр гэрээ байгуулсан боловч ажил гүйцэтгэхтэй холбоотой зарим хүндрэлийн улмаас хэрэгжих хугацаа хойшилж, гэрээний хугацаа хэтэрсэн байна.

2.30 Орхонтуул сумын “Халаалтын зуухны засвар” –ын ажлыг бүрэн гүйцэтгэсэн гэх боловч ажлын гүйцэтгэлийг үнэлж, ашиглалтад хүлээн авсан акт үйлдэгдээгүй байна.

В.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.31 Өмнөх онд дутуу хэрэгжсэн болон санхүүжилтийг бүрэн олгоогүй 7 төсөл арга хэмжээнд 2016 онд 395.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 382.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, Мандал сумын 60 айлын 45, 47 байрны дээврийн их засварын ажил гүйцэтгэгдэж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан боловч дулааны улиралд борооны ус нэвтрэх эсэхийг тогтоож, эрсдэлийг тодорхойлох зорилгоор санхүүжилтээс 12.7 сая төгрөгийг авч үлдсэн байна.

2.32 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд шинээр эхэлж, хэрэгжсэн 358.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээнд нийт 351.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулснаас 339.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, дараах 3 төсөл арга хэмжээнд 11.9 сая төгрөгийг дутуу олгосон байна. Үүнд:

- *Сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ /application/ үүсгэх ажил гэрээт хугацаанд ашиглалтад ороогүй тул гүйцэтгэлийн дагуу 80.0 хувийн санхүүжилтийг олгож, үлдэгдэл 3.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд авч үлдсэн байна.*
- *Орхонтуул сумын Туулын хишиг ОНӨААТҮГ-ын халаалтын зуухны засварын ажлыг гүйцэтгэсэн гэж сэлбэг хэрэгсэл худалдан авсан анхан шатны баримтуудыг бүрдүүлсэн боловч ажлын гүйцэтгэлийг үнэлж, хүлээн авсан акт үйлдэгдээгүй учраас батлагдсан санхүүжилт 8.0 сая төгрөгийг олгоогүй байна.*

В.3 Гэрээт ажил бүрэн хийгдэж дуусаагүй байхад батлагдсан санхүүжилтийг олгосон байна.

2.33 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 73.4 сая төгрөгийн төсөв өртөг бүхий Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор заслын ажлыг 2016 оны 09-р сарын 19-ний өдрөөс 10-р сарын 19-ний өдрийн хооронд гүйцэтгүүлэхээр “Талхун арал” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, 2016 оны 11-р сарын 23-ны өдрийн улсын комиссын хурлаар гадна талын саравчны дээврийн ажлыг дулааны улиралд хийх үүрэг өгсөн буюу гэрээт ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авч, батлагдсан санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.34 Дээрхээс бусад төсөл, арга хэмжээний дутуу болон хуурамч гүйцэтгэлд санхүүжилт олгогдоогүй, зураг төсөвт өөрчлөлт ороогүй байна.

В.4 Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотой зөрчил гараагүй байна.

2.35 Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2016 онд шинээр хэрэгжихээр 29 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд нь тааруулан олгосон бөгөөд хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх төсвийн орлого бүрдээгүйн улмаас 2016-2017 он дамжин хэрэгжих 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг огт эхлүүлэлгүйгээр, дараа онд шилжүүлсэн байна. /Хавсралт №9- д харуулав./

2.36 2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан шилжих болон шинээр эхлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт дутуу батлагдсан, санхүүжилтийг хугацаанд нь олгоогүй зэрэг санхүүжилттэй холбоотой шалтгааны улмаас хэрэгжих хугацаа хойшилсон зөрчил гараагүй бөгөөд гэрээт хугацаанд бүрэн гүйцэтгэгдээгүй, чанарын гүйцэтгэл тодорхой бус ажлуудын холбогдох санхүүжилтийг олгоогүй байна.

В.5 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.

2.37 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжсэн 14 төсөл, арга хэмжээнээс харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан Сүхбаатар сумын ЗДТГ-ын дээврийн засварын ажилд захиалагчийн техник хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гүйцэтгэж, суманд эрх шилсэн 7 төсөл арга хэмжээний хяналтыг орон нутаг нь хэрэгжүүлсэн гэх бөгөөд шууд худалдан авах аргаар гүйцэтгүүлсэн 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн зүгээс ямар ч хяналт хийгдээгүй байна.

2.38 73.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах ажилд техник хяналтын гэрээ ч байгуулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй бөгөөд техник хяналтад ногдох санхүүжилтийг гүйцэтгэгч компанид шилжүүлсэн байна.

2.39 35.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих ажлуудын хэрэгжилт, гүйцэтгэлд мэргэжлийн байгууллага, албан тушаалтнуудаар хяналт хийлгэлгүйгээр өөрсдөө хяналт тавьсан гэж хуваарилагдсан техник хяналтын зардал 0.7 сая төгрөгөөр нөүтбүүк худалдан авсан байна.

2.40 Шууд худалдан авах аргаар гүйцэтгүүлсэн 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын гэрээг дүгнэж, үр дүнг үнэлээгүй байна.

В.6 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан бөгөөд ашиглалтад хүлээн аваагүй байхад санхүүжилт олгосон зөрчил гараагүй байна.

2.41 Тайлант онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн аваагүй зөрчил гараагүй бөгөөд харин Сүхбаатар сумын ЗДТГ-ын гадна саравчны дээврийн ажил хийгдээгүй байхад ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.42 Ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгосон зөрчил илрээгүй байна.

В.7 Аудитын явцад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын хэрэгжилт, ашиглалттай газар дээр нь тулган баталгаажуулахад дараах зөрчил оршиж байлаа. Үүнд:

- *Шаамар сумын ахмадын өргөөнд халаалт тавих ажлыг гүйцэтгүүлэхээр “Поли эрчим” ХХК-тай 6.0 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулан, 7 ширхэг цахилгааны эх үүсвэр бүхий халаалт тавьсан боловч ашиглалтын зардал өндөр гардаг гэдэг шалтгаанаар ашиглагдаагүйгээс өрөө, тасалгаа хүйтэн хэвээр байлаа. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 6.0 сая төгрөгийн зардал гарсан ч энэ нь зорилгоо биелүүлээгүй, үр ашиггүй зардал болсон байна.*
- *15.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Жавхлант сумын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах, гал тогоо, цахилгааны засварын ажлын гүйцэтгэгч “Фронтэйж сэйд” ХХК нь чанарын шаардлага хангахгүй 1, 2-р хоолны тогоо нийлүүлснээс захиалагч тал гүйцэтгэгч компанид хандаж, 1, 2 –р хоолны тогоог солиулж авахаар болсон байна.*
- *2015 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, 2016 оны 06-р сарын 14-ны өдрийн комиссын актаар ашиглалтад хүлээн авсан 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэр бүлийн ёслолын өргөө / монгол гэр / нь ахмад залуу гэр бүлийн ёслолын ордны үндсэн барилга*

ашиглалтад ороогүйн улмаас өнөөг хүртэл ашиглагдахгүй, цас, бороонд норж, тоос шороо дарсан, өнгө үзэмж муудсан байдалтай байлаа.

Өөрөөр хэлбэл, үндсэн барилга нь ашиглалтад ороогүй байхад дагалдах хөрөнгүүдийг худалдан авснаас ашиглагдахгүй, элэгдэлд орж байна.



ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Улсын төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, баталсан 23.4 сая төгрөг,
- 19.4 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “Сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ үүсгэх “ ажлын гүйцэтгэл 80.0 хувь гэж үнэлэгдсэн бөгөөд гэрээт хугацаанд ашиглалтад ороогүй, дутуу хийгдсэн ажлын өртөг 3.9 сая төгрөг,
- Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах 73.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчээр тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан компанийг сонгон шалгаруулсан бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлд техникийн хяналт хийлгэлгүйгээр, техник хяналтад ногдох зардлыг гүйцэтгэгч компанид шилжүүлсэн байна.
- Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор заслын 73.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчээр шаардлага хангахгүй баримт, материал ирүүлсэн болон өмнөх хөрөнгө оруулалтын ажлуудын гэрээний үүргээ гүйцэтгээгүйгээс төсвийн хөрөнгийг шамшигдуулсан Талхун-арал компанийг сонгон шалгаруулсан бөгөөд гэрээт ажил бүрэн хэрэгжээгүй байхад ашиглалтад хүлээн авч, гүйцэтгэгдээгүй ажлын санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн байна.
- Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих ажлуудын хэрэгжилт, гүйцэтгэлд мэргэжлийн байгууллага, албан тушаалтнуудаар хяналт хийлгэлгүйгээр, хуваарилагдсан техник хяналтын зардал 0.7 сая төгрөгөөр нөүтбүүк худалдан авсан байна.
- Орхонтуул сумын Туулын хишиг ОНӨААТҮГ-ын халаалтын зуухны засварын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулж, гүйцэтгэсэн гэж сэлбэг хэрэгсэл худалдан авсан анхан шатны баримтуудыг бүрдүүлсэн боловч ажлын гүйцэтгэлийг үнэлж, хүлээн авсан акт үйлдээгүй учраас батлагдсан санхүүжилт 8.0 сая төгрөгийг олгоогүй зэрэг нийт **182.9 сая** төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага бичигдлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсөвт байгууллагуудын хөрөнгийн болон урсгал зардлаас гадна орон нутгийн төсөвт байгууллагуудад автомашин, техник, тоног төхөөрөмж худалдан авах, хөшөө дурсгал босгох зэрэг нэн тэргүүний ач холбогдолтой бус төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- 17 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг урьдчилан тооцолгүйгээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.
- Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.
- Халаалтын шугам, зуух шинэчлэх зэрэг улирлын шинж чанартай төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдсан байна.
- Өмнөх онд бүрэн хэрэгжсэн боловч санхүүжилт дутуу олгогдсон, он дамжин хэрэгжсэн зэрэг нийт 6 ажлын санхүүжилтийг бүрэн олгосон бөгөөд ашиглалтад хүлээн авсан боловч чанарын эрсдэлийг шалгах шаардлагатай 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд авч үлдсэн байна.
- 2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан шинээр эхлэх төсөл, арга хэмжээний 44.8 хувь нь бүрэн, 3.4 хувь нь дутуу хэрэгжиж, 51.8 хувь нь дараа онд шилжсэн байна.
- Зарим төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй байхад улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- Халаалт дулааны шугам, зуух засварын ажлуудын техник хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй байна.
- Шууд худалдан авах аргаар гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй байна.
- Зарим төсөл, арга хэмжээ чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргил, ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа нарт:

- Улсын төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардал, нэн тэргүүний ач холбогдолгүй автомашин, техник тоног төхөөрөмж бэлтгэх, хөшөө дурсгал босгох зэрэг төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй байх.
- Зураг, төсөв нь хийгдсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх.

- Сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ үүсгэх ажлын гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээг дүгнэж, гэрээт ажлыг бүрэн гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авах.
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, бичиг баримтын шаардлага хангаагүй болон өмнөх гэрээт ажлаа ашиглалтад хүлээлгэн өгөөгүй, төсөвт их хэмжээний хохирол учруулсан компанийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулах зөрчлийг таслан зогсоох.
- Хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлд тавих техникийн хяналтыг сайжруулах, гэрээт ажлаа бүрэн гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авахгүй, санхүүжилтийг шилжүүлэхгүй байх.
- Улсын комиссын актаар хүлээн авсан боловч бүрэн хийгдээгүй Сүхбаатар сумын ЗДТГ-ын дээврийн болон дотор засварын ажлыг дуусгах.
- Төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэхдээ хугацаа алдахгүй байх, санхүүжилтийг цаг хугацаанд нь шийдвэрлэх, эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэл, гэрээний биелэлтэд хяналт тавьж байх.
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй болон бүрэн хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон төрийн албан хаагчдад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох.

БҮЛЭГ 3

ЗАСГИЙН ГАЗРААС ОЛГОСОН ВЕКСЕЛИЙН ҮР ДҮН

А.4 Векселиэр санхүүжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээг өөр эх үүсвэрээр санхүүжүүлэхээр давхар тусгаагүй байна.

3.1 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт, оруулах тухайн хуулийн 4-р хавсралтаар Сэлэнгэ аймагт эрх нь шилжсэн, 2010-2013 онуудад хэрэгжиж эхэлсэн 9 төсөл, арга хэмжээний үлдэгдэл, төлбөрийг 2016 онд векселиэр гүйцэтгэхээр баталсан байна. /Хавсралт №3-аас харах /

3.2 Векселиэр санхүүжүүлэхээр тусгасан дээрх 9 төсөл, арга хэмжээг өөр эх үүсвэрээр санхүүжүүлэхээр давхар тусгаагүй байна.

Б.3 Векселиэр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 55.5 хувь нь бүрэн ашиглалтад орсон байна.

3.3 Векселиэр санхүүжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс, Худалдааны төвийн барилга, Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээний ажлуудыг 2015 онд, Мандал сумын Тарни багийн 50 ортой, Баянгол сумын 75 ортой, Сүхбаатар сумын 75 ортой цэцэрлэгийн барилгуудыг 2016 онд тус тус улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9

№	Барилга угсралтын ажлын нэр	Улсын комиссын	
		Актын огноо дугаар	Бүрэлдэхүүн

1	Мандал сумын Тарни багийн 50 ортой цэцэрлэгийн барилга	2015.12.08 №50/2015	Дарга, нарийн бичгийн дарга, 10 гишүүн нийт 12
2	Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2015.11.30 №40/2015	Дарга, нарийн бичгийн дарга 10 гишүүн нийт 12
3	Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээ	2015.09.09 №24/2015	Дарга, нарийн бичгийн дарга 10 гишүүн нийт 11
4	Баянгол сумын 75 ортой цэцэрлэгийн барилга	2016.05.30 №10/2016	Дарга, нарийн бичгийн дарга, 10 гишүүн нийт 12
5	Сүхбаатар сумын 75 ортой цэцэрлэгийн барилга	2016.01.19 №02/2016	Дарга, нарийн бичгийн дарга 10 гишүүн нийт 12

3.4 Векселиэр санхүүжүүлэхээр тусгагдсан дараах төсөл, арга хэмжээ ашиглалтад ороогүй байна Үүнд:

- Сүхбаатар сумын сургуулийн барилга, спорт заалны 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын агааржуулагч, салхивчны тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийгдээгүйгээс огт ашиглаагүй болон гадна тохижилтын ажил дутуу хийгдсэн байхад 2015 оны 12-р сарын 20-ны өдрийн 45/2015 дугаар бүхий актаар улсын комисс ашиглалтад хүлээн авч, гүйцэтгэгч Саруул цамхаг компанид 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг векселиэр бүрэн олгосон байна.



Сүхбаатар сумын сургуулийн салхивч, агааржуулагчийн хоолой, гадна талбайн байдал / 2017-03-27 /

- Мандал сумын Хэрх тосгоны 10 ортой эмнэлгийн барилга угсралтын 582.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг гүйцэтгэгч Дакон констракшн компани 2011 оноос хэрэгжүүлж эхэлсэн боловч дулаанаар хангагч “Хэрх элч” компанийн зуухны хүчин чадал хүрэлцэхгүй гэсэн үндэслэлээр уг барилга угсралтын ажил зогсож, 2014 онд зуухны өргөтгөл хийгдэснээр тус эмнэлгийг дулаанаар хангах боломжтой болсон байна. Гэвч 2013 оноос хойш зогссон барилга угсралтын ажлыг гүйцээж, ашиглалтад оруулаагүй бөгөөд аймаг болон ашиглагч байгууллагын зүгээс ЭМЯ-нд удаа дараа санал тавьж, 2016 оны төсөвт үлдэгдэл санхүүжилтийг суулгасан боловч нэмж ажил гүйцэтгээгүй, санхүүжилт олгогдоогүй байна. Аймгийн ГХБХБГ-ын мэдээгээр барилга угсралтын ажил 80,0 хувийн гүйцэтгэлтэй, дотор засал болон гадна инженерийн ажил дутуу хийгдсэн байдалтай байна.



/ Мандал сумын Хэрх тосгоны 10 ортой эмнэлгийн барилга /
/2017.03.28/


- Аймгийн Эрүүл мэндийн төвийн 180.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий засварын ажлыг гүйцэтгэгч Есүй-Ордон компани 2013 оноос хэрэгжүүлж, барилгын засварын ажлыг хугацаанд нь дуусгасан бөгөөд чанарын шаардлага хангахгүй зарим тоног, төхөөрөмжийг ашиглагчийн зүгээс буцаасныг бүрэн нийлүүлээгүй тул ашиглалтад хүлээн аваагүй байна. Гэвч уг ажлыг ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт үйлдэгдээгүй байхад 2016 онд үлдэгдэл 52.6 сая төгрөгийн санхүүжилтийг векселиэр бүрэн олгосон байна.
- Ерөө сумын үйлчилгээний төвийн барилга угсралтын 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр “СБУ” компани ажиллаж, 2012 онд 187.0 сая төгрөг, 2015 онд 54.7 сая төгрөг, 2016 онд үлдэгдэл 8.3 сая төгрөгийн санхүүжилтийг векселиэр бүрэн олгосон боловч барилгын ажил эхлэл төдий байна. Уг барилгыг 2012 онд эхэлснээс хойш 5 жил өнгөрсөн бөгөөд хийгдсэн барилгын суурь, ханан дээр барилга угсралтын ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой эсэхийг мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах нь зүйтэй гэж үзэж байна.
Барилга хөгжлийн төвийн 2014 оны 9-р сарын 22-ны өдрийн 1281/2014 дугаар бүхий магадлалын ерөнхий дүгнэлтээр дээрх барилгын нийт төсөвт өртгийг 721.6 сая төгрөгөөр хянан баталгаажуулсан байна.



250,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон Ерөө сумын үйлчилгээний төвийн барилга
/ 2017.04.08 /

3.5 Аудитын явцад 2016 онд векселиэр төлбөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтыг газар дээр нь тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд оршиж байлаа. Үүнд:

- Сүхбаатар сумын 75 ортой цэцэрлэгийн барилгын 600.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг 2016 оны 1-р сарын 19-ны өдөр улсын комисс ашиглалтад хүлээн авч, дутуу ажлыг 2016 оны 5 сард хийж дуусгах үүрэг өгсөн боловч хэрэгжүүлээгүйн улмаас анги танхим, өрөө тасалгаануудад борооны ус гоожиж, паркетан шал нь норсон байна. Гүйцэтгэгч компанийн зүгээс дээврийг цементэлсэн боловч ус гоожиж бохирдсон дотоод заслыг гүйцэтгээгүй байна.



Цэцэрлэгийн дотор тааз / 2017.03.27 /

- 655.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Баянгол сумын 75 ортой цэцэрлэгийн барилгын гал тогооны өрөөний уур шүүгч, агааржуулагч ажиллахгүй байгаагаас хана, таазыг уур цохиж, будаг, шохой ховхорч хууларсан байдалтай байлаа.
- Сүхбаатар сумын сургуулийн 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга, спорт заалны ажлын хүрээнд спорт, урлаг заал, хоолны өрөөний шал, салхивчны ажил бүрэн хийгдсэн боловч салхивч, агааржуулагчийг туршилтын журмаар ажиллуулж, хүлээлгэж өгөөгүйгээс ашиглагдаагүй байгаа бөгөөд гадна талбайн зүлэгжүүлэлт, сагсны шийд огт хийгдээгүй, хашааны будаг, талбайн цемент дутуу хийгдсэн байлаа.

Б.7 Векселиэр санхүүжилт авсан зарим гүйцэтгэгч компани төсвийн ерөнхийлөн захирагчтай тооцоо нийлж, магадлашгүй ажил, норм норматив, зураг төсөв, техник хяналтын зардлыг буцаан төвлөрүүлээгүй байна.

3.6 Сэлэнгэ аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, 2016 оны Төсвийн тухай хуульд үлдэгдэл төлбөрийг векселиэр гүйцэтгэхээр баталсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч дараах компаниуд санхүүжилтээ бүрэн авсан боловч аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчтай тооцоо нийлж, гэрээнд тусгагдсан зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын болон магадлашгүй ажлын зардал зэрэг нийт 37.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №10 /сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний үнэ	Зураг төсвийн үнэ	Техник хяналтын зардал	Магадлашгүй ажлын зардал
1	Цэцэрлэгийн барилга 75 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	250.0	5.0	4.3	-
2	Сургуулийн барилга, спорт заал /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	500.0	12.0	9.6	6.5
	НИЙТ	750.0	17.0	13.9	6.5

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Векселиэр санхүүжүүлсэн төсөл ,арга хэмжээтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Эрүүл мэндийн төвийн засвар, Ерөө сумын үйлчилгээний төвийн барилга угсралтын ажил, Мандал сумын Хэрх тосгоны эмнэлгийн барилга угсралтын ажлуудыг гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байна.
- Эрүүл мэндийн төвийн засварын ажлын хүрээнд тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдээгүй, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн аваагүй байхад үлдэгдэл санхүүжилтийг олгосон 52.6 сая төгрөг,
- Сүхбаатар сумын сургуулийн барилга, спорт заалны ажлын хүрээнд агааржуулагч, салхивчны тохируулга, туршилт хийгдэж, хүлээлгэж өгөөгүй, гадна тайлбайн ажлууд дутуу хийгдсэн байхад улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон 500.0 сая төгрөг,
- Гүйцэтгэгч нь санхүүжилтийг векселиэр авсан боловч ТЕЗ-тай тооцоо нийлж, техник хяналт, зураг төсөв, магадлашгүй ажлын зардлыг буцаан төвлөрүүлээгүй 37.4 сая төгрөг зэрэг нийт **590.0 сая** төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- 2016 оны Төсвийн тухай хуульд векселиэр төлбөр гүйцэтгэхээр баталсан 9 төсөл, арга хэмжээний 55.5 хувь нь бүрэн хэрэгжсэн байна.
- Төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусаагүй байхад улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг векселиэр олгосон байна.
- Төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар ашиглалтад хүлээн аваагүй байхад үлдэгдэл санхүүжилтийг векселиэр бүрэн олгосон байна.
- Векселиэр санхүүжилтээ авсан зарим гүйцэтгэгч компаниуд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчтай тооцоо нийлж, холбогдох зардлыг буцаан төвлөрүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргил, ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа нарт:

- Сүхбаатар сумын сургуулийн барилга, спорт заалны ажлын гүйцэтгэгч Саруул цамхаг ХХК-иар дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгүүлэх, бүрэн гүйцэтгэгдээгүй ажлыг ашиглалтад хүлээн авсан улсын комиссын гишүүдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.
- Эрүүл мэндийн төвийн засвар, шинэчлэлийн ажлын гүйцэтгэгч Есүй ордон ХХК-иар дутуу нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг бэлтгүүлэх, хөрөнгө оруулалтын ажлыг ашиглалтад хүлээн авах.

- Ерөө сумын үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагуудаар үнэлэлт, дүгнэлт гаргуулах, нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлж, барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах.
- Мандал сумын Хэрх тосгоны 10 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр ажилласан Дакон констракшн компаниар ажлыг бүрэн дуусгуулах арга хэмжээ авч, ашиглалтад оруулах.
- ТЕЗ-тай тооцоо нийлж, зураг төсөв, техникийн хяналт болон магадлашгүй ажлын зардлыг төвлөрүүлээгүй компаниудаар дээрх зардлыг нөхөн гаргуулах арга хэмжээ авах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЖЭЭЧ

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Э.ЭРДЭНЭЗУЛ

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн
төсөл, арга хэмжээ /сая.төгрөг/**

№	Хэрэгжих сум	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх дуусах хугацаа	2016 оны хуулинд тусгах төсөвт өртөг /сая төг/	2016 онд санхүүжих дүн /сая төг/
1	Алтанбулаг	Спорт цогцолборын барилга	2016-2016	1,000.0	1,000.0
2	Алтанбулаг	Эрүүл мэндийн төвийн барилга	2016-2016	800.0	800.0
3	Баруунбүрэн	Сумын төвийн шинэчлэл	2016-2016	5,000.0	5,000.0
4	Зүүнбүрэн	Сургуулийн өргөтгөлийн барилга барих	2016-2016	1,000.0	1,000.0
5	Зүүнбүрэн	Ахуйн үйлчилгээний барилга барих	2016-2016	650.0	650.0
6	Мандал	Хүүхэд залуучуудын соёл, спортын цогцолбор барих	2016-2016	3,308.2	3,308.2
7	Мандал	Бохир усны нэгдсэн шугамын барилга	2016-2016	1,637.0	1,637.0
8	Мандал	Төвлөрсөн дулааны системийн шугамд холбох	2016-2016	11,897.4	11,897.4
9	Орхон	100 ортой сургуулийн дотуур байрны барилга барих	2016-2016	1,000.0	1,000.0
10	Орхон	Дархан-Эрдэнэтийн чиглэлийн замаас сумын төв хүртэл 5 км хатуу хучилттай зам тавих	2016-2016	4,000.0	4,000.0
11	Цагааннуур	2 дугаар багийн төвд 180 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих	2016-2016	1,500.0	1,500.0
12	Сайхан	Сургуулийн дотуур байрны барилга барих	2016-2016	2,000.0	2,000.0
13	Хүдэр	Эрүүл мэндийн төвийн барилга шинээр барих	2016-2016	1,000.0	1,000.0
14	Сүхбаатар	Дулааны станцын 3-р зуухны шинэчлэлт	2016-2016	1,535.0	1,535.0
15	Сүхбаатар	Салхит багт 100 ортой цэцэрлэгийн барилга барих	2016-2016	800.0	800.0
16	Хушаат	50 ортой цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих	2016-2016	650.0	650.0
17	Түшиг	Сумын Засаг даргын тамгын газрын байр шинээр барих	2016-2016	600.0	600.0
18	Сайхан	Соёлын төвүүдийн дээврийн засвар	2016-2016	137.0	137.0
19	Шаамар сумын Дулаанхан тосгон	Дулаанхан тосгоны сургуулийн барилгын засварын ажил	2016-2016	198.8	198.8
20	Сүхбаатар	Спортын ордны их засвар	2016-2016	628.3	628.3

21	Сүхбаатар	Нэгдсэн эмнэлгийн их засвар	2016-2016	2,603.4	2,603.4
22	Жавхлант	Сургуулийн барилгын их засвар	2016-2016	385.6	385.6
23	Хушаат	Сургуулийн барилгын их засвар	2016-2016	800.0	800.0
24	Сүхбаатар	Дулааны станцын хими ус цэвэрлэгээ, ус зөөлрүүлэх төхөөрөмжийн шинэчлэлт	2016-2016	150.0	150.0
25	Сүхбаатар	Орон сууцны айлуудыг цэвэр усны тоолууржуулах	2016-2016	300.0	300.0
		НИЙТ		43,580.7	43,580.7

Судалгаа гаргасан: Шинжээч: Э.Эрдэнэзул

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2016 онд шинээр хэрэгжихээр
батлагдсан төсөл, арга хэмжээ /сая.төгрөг/**

Д/ д	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
1	Сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/	2016	2016	120.0	120.0
2	2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2016	2016	80.0	80.0
3	“Номт хан” өрхийн эмнэлгийн их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2016	2016	30.0	30.0
	НИЙТ			230.0	230.0

Судалгаа гаргасан: Шинжээч: Э.Эрдэнэзул

**Үлдэгдэл санхүүжилтийг 2016 онд векселиэр гүйцэтгэхээр баталсан төсөл, арга
хэмжээ /сая.төгрөг/**

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2016 онд санхүүж их дүн	2016 онд гарсан гүйцэтгэл
1	Век-Х.1.1.5	Цэцэрлэгийн барилга 50 ор /Сэлэнгэ, Мандал сум, Тарни баг/	2013	2016	350.0	54.8	54.8
2	Век-Х.1.1.6	Цэцэрлэгийн барилга 75 ор /Сэлэнгэ, Баянгол сум/	2011	2016	655.0	74.9	74.9
3	Век-Х.1.1.7	Цэцэрлэгийн барилга 75 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2011	2016	600.0	52.7	52.7
4	Век-Х.1.2.1.2	Худалдааны төвийн барилга /аймгийн төвд/	2012	2016	3,000.0	303.1	295.3
5	Век-Х.1.1.24	Эмнэлгийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон/	2013	2016	582.0	97.5	-
6	Век-Х.1.2.7	Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн төвийн засвар /шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт	2013	2016	180.0	52.6	52.6
7	Век-Х.1.1.116	Сургуулийн барилга, спорт заал /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2010	2016	3,440.0	500.0	500.0
8	Век-Х.1.1.4	Үйлчилгээний төвийн барилга /Сэлэнгэ, Ерөө сум/	2012	2016	250.0	8.3	8.3
9	Век-Х.1.3	Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээ /Сэлэнгэ, Сайхан сум/	2013	2016	1,474.4	146.7	146.7
		НИЙТ			10,531.4	1,290.6	1,185.3

Судалгаа гаргасан: Шинжээч: Э.Эрдэнэзул

**2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр батлагдсан
төсөл, арга хэмжээ /сая.төгрөг/**

№	ТАХ-ний нэр	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
Шилжих хөрөнгө оруулалт				
1	Сүхбаатар сумын Шүдэнзний арын 4 дүгээр багт дулаан болон цэвэр усны шугам татах	2015-2016	411.6	211.0
2	Сүхбаатар сумын 2 дугаар багийг камержуулж, цагдаагийн газрын нэгдсэн хяналтын системд холбох	2015-2016	78.0	30.0
3	Д.Оюунболд агсны хөшөө	2015-2016	5.0	5.0
4	Аймгийн ахмад, залуу гэр бүлийн ёслолын өргөө авах	2015-2016	50.0	49.6
5	Аймгийн ахмад, залуу гэр бүлийн ёслолын өргөөнд тавилга хэрэгсэл авах	2015-2016	30.0	30.0
6	Мандал сумын 60 айлын 45, 47-р байрны дээврийн их засвар	2015-2016	84.6	67.5
7	Аймгийн ЗДТГ-ын дулааны шугамын өргөтгөл, шинэчлэл	2015-2016	50.1	2.5
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт				
1	Бүх сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ /application/ үүсгэх	2016-2016	21.0	21.0
2	Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах	2016-2016	73.5	73.5
3	Мэргэжлийн хяналтын лабораторид химийн урвалж бодис авах	2016-2016	6.0	6.0
4	Баянгол сумын хүүхэд хөгжлийн төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт	2016-2017	619.2	20.0
5	Зүүнбүрэн сумын сургуульд мэдээлэл зүйн кабинет байгуулах	2016-2017	20.0	20.0
6	Сүхбаатар сумын барилгын 27 дугаар байрыг хэрэглээний халуун усны шугаманд холбох	2016-2017	20.0	20.0
7	Шаамар сумын шинэ цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, хашаа барих	2016-2017	19.6	19.6
8	Шаамар сумын Дулаанхаан тосгонд явган хүний зам барих	2016-2017	7.0	7.0
9	Аймгийн ЗДТГ-т үйлчилгээний микробус автомашин авах	2016-2016	45.0	45.0
10	Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антен авах	2016-2016	8.4	8.4
11	Аймгийн Прокурорын газар тавилга худалдан авах	2016-2016	9.0	9.0
12	Сэлэнгэ долгио чуулгад тоног төхөөрөмж худалдан авах	2016-2016	38.5	38.5
13	Орхонтуул сумын Рашаант тосгоны 2 дугаар сургуулийн тоног төхөөрөмж шинэчлэл	2016-2017	26.6	26.6
14	Сант сумын сургуулийн зааланд тоног төхөөрөмж авах	2016-2017	20.0	20.0
15	Сайхан суманд ус зөөлрүүлэх төхөөрөмж авах	2016-2017	26.8	26.8

16	Түшиг сумын эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	2016-2017	20.0	20.0
17	Хушаат сумын эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	2016-2017	20.0	20.0
18	Цагааннуур сумын сургуулийн гал тогоонд тоног төхөөрөмж авах	2016-2017	20.0	20.0
19	Жавхлант сумын соёлын төвд хөгжим, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах	2016-2017	29.1	20.0
20	Шаамар сумын ахмадын өргөөнд халаалт тавих	2016-2016	6.0	6.0
21	Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор засварын ажил	2016-2016	73.4	73.4
22	Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих	2016-2016	35.0	35.0
23	Орхонтуул сумын халаалтын зуухны засвар	2016-2016	8.0	8.0
24	Жавхлант сумын сургуулийн гал тогооны засвар	2016-2016	15.0	15.0
25	Шаамар сумын цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж цэвэр усны шугам нийлүүлэх гэрээ	2016-2016	10.0	10.0
26	Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн сантехник засвар	2016-2016	10.0	10.0
27	Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцны дотор сантехник засвар	2016-2017	20.0	20.0
28	Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар	2016-2017	20.0	20.0
29	Хүдэр сумын ЗДТГ-ын их засвар	2016-2017	20.0	20.0
НИЙТ			1,976.3	1,054.2

Судалгаа гаргасан: Шинжээч: Э.Эрдэнэзул

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсөв нь батлагдсан төсөл, арга хэмжээг тусгасан эсэх талаарх судалгаа /сая.төгрөг/

№	ТАХ-ний нэр	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн	Зураг төсөв батлагдсан эсэх
1	Бүх сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ /application/ үүсгэх	2016-2016	21.0	21.0	Тооцоо судалгаа хийгдээгүй
2	Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах	2016-2016	73.5	73.5	Зураг төсөв хийгдсэн
3	Мэргэжлийн хяналтын лабораторид химийн урвалж бодис авах	2016-2016	6.0	6.0	Тооцоо судалгаа хийгдээгүй
4	Баянгол сумын хүүхэд хөгжлийн төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт	2016-2017	619.2	20.0	Зураг төсөв хийгдээгүй
5	Зүүнбүрэн сумын сургуульд мэдээлэл зүйн кабинет байгуулах	2016-2017	20.0	20.0	Зураг төсөв хийгдээгүй
6	Сүхбаатар сумын барилгын 27 дугаар байрыг хэрэглээний халуун усны шугаманд холбох	2016-2017	20.0	20.0	Зураг төсөв хийгдээгүй
7	Шаамар сумын шинэ цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, хашаа барих	2016-2017	19.6	19.6	Зураг төсөв хийгдээгүй
8	Шаамар сумын Дулаанхаан тосгонд явган хүний зам барих	2016-2017	7.0	7.0	Зураг төсөв хийгдээгүй
9	Аймгийн ЗДТГ-т үйлчилгээний микробус автомашин авах	2016-2016	45.0	45.0	Тооцоо судалгаа хийгдсэн
10	Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антен авах	2016-2016	8.4	8.4	Тооцоо судалгаа хийгдсэн
11	Аймгийн Прокурорын газар тавилга худалдан авах	2016-2016	9.0	9.0	Тооцоо судалгаа хийгдээгүй
12	Сэлэнгэ долгио чуулгад тоног төхөөрөмж худалдан авах	2016-2016	38.5	38.5	Тооцоо судалгаа хийгдсэн
13	Орхонтуул сумын Рашаант тосгоны 2 дугаар сургуулийн тоног төхөөрөмж шинэчлэл	2016-2017	26.6	26.6	Тооцоо судалгаа хийгдээгүй
14	Сант сумын сургуулийн зааланд тоног төхөөрөмж авах	2016-2017	20.0	20.0	Тооцоо судалгаа хийгдээгүй
15	Сайхан суманд ус зөөлрүүлэх төхөөрөмж авах	2016-2017	26.8	26.8	Тооцоо судалгаа хийгдээгүй
16	Түшиг сумын эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	2016-2017	20.0	20.0	Тооцоо судалгаа хийгдээгүй
17	Хушаат сумын эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	2016-2017	20.0	20.0	Тооцоо судалгаа хийгдээгүй
18	Цагааннуур сумын сургуулийн гал тогоонд тоног төхөөрөмж авах	2016-2017	20.0	20.0	Тооцоо судалгаа хийгдээгүй
19	Жавхлант сумын соёлын төвд хөгжим, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах	2016-2017	29.1	20.0	Тооцоо судалгаа хийгдээгүй
20	Шаамар сумын ахмадын өргөөнд халаалт тавих	2016-2016	6.0	6.0	Зураг төсөв хийгдээгүй
21	Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор засварын ажил	2016-2016	73.4	73.4	Зураг төсөв хийгдсэн

22	Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих	2016-2016	35.0	35.0	Зураг төсөв хийгдсэн
23	Орхонтуул сумын халаалтын зуухны засвар	2016-2016	8.0	8.0	Зураг төсөв хийгдээгүй
24	Жавхлант сумын сургуулийн гал тогооны засвар	2016-2016	15.0	15.0	Зураг төсөв хийгдээгүй
25	Шаамар сумын цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж цэвэр усны шугам нийлүүлэх гэрээ	2016-2016	10.0	10.0	Тооцоо судалгаа хийгдсэн
26	Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн сантехник засвар	2016-2016	10.0	10.0	Зураг төсөв хийгдсэн
27	Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцны дотор сантехник засвар	2016-2017	20.0	20.0	Зураг төсөв хийгдээгүй
28	Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар	2016-2017	20.0	20.0	Зураг төсөв хийгдээгүй
29	Хүдэр сумын ЗДТГ-ын их засвар	2016-2017	20.0	20.0	Зураг төсөв хийгдээгүй
	НИЙТ		1,267.0	658.7	

Судалгаа гаргасан: Шинжээч: Э.Эрдэнэзул

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаарх судалгаа /сая.төгрөг/

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	ХАА-нд мөрдөх журам	ХАА-г зохион байгуулсан газар
1	Бүх сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ /application/ үүсгэх	21.0	Харьцуулалтын арга /ХА/	Орон нутгийн өмчийн газар
2	Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах	73.5	ХА	Мандал сумын ЗДТГ
3	Мэргэжлийн хяналтын лабораторид химийн урвалж бодис авах	6.0	Шууд гэрээ байгуулах /ШГБ/	Аймгийн ЗДТГ
4	Аймгийн ЗДТГ-т үйлчилгээний микробус автомашин авах	45.0	ХА	Орон нутгийн өмчийн газар
5	Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антен авах	8.4	ШГБ	Аймгийн ЗДТГ
6	Аймгийн Прокурорын газар тавилга худалдан авах	9.0	ШГБ	Аймгийн Прокурорын газар
7	Сэлэнгэ долгио чуулгад тоног төхөөрөмж худалдан авах	38.5	ХА	Орон нутгийн өмчийн газар
8	Шаамар сумын ахмадын өргөөнд халаалт тавих	6.0	ШГБ	Шаамар сумын ЗДТГ
9	Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор засварын ажил	73.4	ХА	Аймгийн ЗДТГ
10	Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих	35.0	ХА	Баруунбүрэн сумын ЗДТГ
11	Орхонтуул сумын халаалтын зуухны засвар	8.0	ШГБ	“Туулын хишиг” ОНӨААТҮГ
12	Жавхлант сумын сургуулийн гал тогооны засвар	15.0	ХА	Жавхлант сумын ЗДТГ
13	Шаамар сумын цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж цэвэр усны шугам нийлүүлэх гэрээ	10.0	ШГБ	Шаамар сумын ЗДТГ
14	Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн сантехник засвар	10.0	ШГБ	Аймгийн ЗДТГ
	НИЙТ	358.8		

Судалгаа гаргасан: Шинжээч: Э.Эрдэнэзул

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлт /сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Хэмнэлт
1	Бүх сумдыг цахим хуудастай болгох, төрийн үйлчилгээний хэрэглээний программ /application/ үүсгэх	21.0	19.4	1.6
2	Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах	73.5	73.0	0.5
3	Мэргэжлийн хяналтын лабораторид химийн урвалж бодис авах	6.0	6.0	-
4	Аймгийн ЗДТГ-т үйлчилгээний микробус автомашин авах	45.0	44.0	1.0
5	Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антен авах	8.4	5.0	3.4
6	Аймгийн прокурорын газар тавилга худалдан авах	9.0	9.0	-
7	Сэлэнгэ долгио чуулгад тоног төхөөрөмж авах	38.5	38.5	-
8	Шаамар сумын ахмадын өргөөнд халаалт тавих	6.0	6.0	-
9	Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор засварын ажил	73.4	73.4	-
10	Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих	35.0	34.8	0.2
11	Орхонтуул сумын халаалтын зуухны засвар	8.0	8.0	-
12	Жавхлант сумын сургуулийн гал тогооны засвар	15.0	13.9	1.1
13	Шаамар сумын цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж цэвэр усны шугам нийлүүлэх гэрээ	10.0	10.0	-
14	Сүхбаатар сумын 2-р цэцэрлэгийн сантехник засвар	10.0	10.0	-
	НИЙТ	358.8	351.0	7.8

Судалгаа гаргасан: Шинжээч: Э.Эрдэнэзул

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ашиглалтад
хүлээн авсан байдал**

№	Төсөл, арга хэмжээний нэр	Ашиглалтад хүлээн авсан огноо	Улсын комиссын	
			Актын дугаар	Бүрэлдэхүүн
1	Мандал сумын Түнхэл тосгоны халаалтын зуух, шугамыг шинээр угсарч суурилуулах	2016.11.17	08	Дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүн нийт 7
2	Мэргэжлийн хяналтын лабораторид химийн урвалж бодис авах	2016.12.12	51	Дарга, 4 гишүүн нийт 5
3	Аймгийн ЗДТГ-т үйлчилгээний "микробус" автомашин авах	2016.11.16	09	Дарга, 4 гишүүн нийт 5
4	Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антен авах	2016.06.13	03	Дарга, 1 гишүүн нийт 2
5	Аймгийн прокурорын газарт тавилга	2016.06.10	01	Дарга, 2 гишүүн нийт 3
6	Сэлэнгийн долгио чуулгад тоног төхөөрөмж авах	2016.11.03	-	Дарга, 2 гишүүн нийт 3
7	Шаамар сумын ахмадын өргөөнд халаалт тавих	2016.10.21	02	Дарга, 2 гишүүн нийт 3
8	Сүхбаатар сумын ЗДТГ-ын барилгын дээвэр, дотор заслын ажил	2016.11.23	42	Дарга, нарийн бичгийн дарга, 6 гишүүн нийт 8
9	Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дэх байрнуудад халаалт тавих	2016.11.15	ХАА-1307/610	Дарга, нарийн бичгийн дарга 4 гишүүн нийт 6
10	Жавхлант сумын сургуулийн гал тогооны засвар	2016.11.08	01	Дарга, 2 гишүүн нийт 3
11	Шаамар сумын цэцэрлэгт цэвэр усны шугам татах, гал тогооны тоног төхөөрөмж авах	2016.10.14	01	Дарга, 2 гишүүн нийт 3
12	Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн сантехник засвар	2016.10.28	27	Дарга, нарийн бичгийн дарга 3 гишүүн нийт 5

Судалгаа гаргасан: Шинжээч: Э.Эрдэнэзул

2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан боловч дараа онд шилжсэн төсөл, арга хэмжээ /сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх дуусах хугацаа	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих дүн
1	Баянгол сумын хүүхэд хөгжлийн төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт	2016-2017	619.2	20.0
2	Зүүнбүрэн сумын сургуульд мэдээлэл зүйн кабинет байгуулах	2016-2017	20.0	20.0
3	Сүхбаатар сумын барилгын 27 дугаар байрыг хэрэглээний халуун усны шугаманд холбох	2016-2017	20.0	20.0
4	Шаамар сумын шинэ цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, хашаа барих	2016-2017	19.6	19.6
5	Шаамар сумын Дулаанхаан тосгонд явган хүний зам барих	2016-2017	7.0	7.0
6	Орхонтуул сумын Рашаант тосгоны 2 дугаар сургуулийн тоног төхөөрөмж шинэчлэл	2016-2017	26.6	26.6
7	Сант сумын сургуулийн зааланд тоног төхөөрөмж авах	2016-2017	20.0	20.0
8	Сайхан суманд ус зөөлрүүлэх төхөөрөмж авах	2016-2017	26.8	26.8
9	Түшиг сумын эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	2016-2017	20.0	20.0
10	Хушаат сумын эмнэлэгт түргэн тусламжийн машин авах	2016-2017	20.0	20.0
11	Цагааннуур сумын сургуулийн гал тогоонд тоног төхөөрөмж авах	2016-2017	20.0	20.0
12	Жавхлант сумын соёлын төвд хөгжим, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах	2016-2017	29.1	20.0
13	Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцны дотор сантехник засвар	2016-2017	20.0	20.0
14	Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар	2016-2017	20.0	20.0
15	Хүдэр сумын ЗДТГ-ын их засвар	2016-2017	20.0	20.0
	НИЙТ		908.3	300.0

Судалгаа гаргасан : Шинжээч: Э.Эрдэнэзул

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ:



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: 7036-2223

2017.04.13 № 1/391
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай ирүүлсэн 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 40 тоот "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын төсөлтэй санал нийлж байна.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



My Doc /Zasag darga/ Jijig toot



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: 7036-2127, 7036-3597

2017.04.10 № 76
танай _____-ны № _____-т


СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН

ГАЗАРТ

2017 оны 4-р сарын 08-ны 41 тоот албан бичгийн хариу хүргүүлж байна."Улс,орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангын төслийг хүлээн авч танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал манай байгууллагад байхгүй болно.

ДАРГА



П.ЭРДЭНЭСАЙХАН



**“СЭЛЭНГЭ БАРИЛГА ЗАХИАЛАГЧ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум,
Аймгийн ЗДТГ-ын 124 тоот
Утас/факс: 7036-2536
E-mail: bz_selenge@yahoo.com

᠒᠐17. 04. 13 № 19
танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
санал нийлж байна. Цаашид өгсөн зөвлөмжийн
дагуу ажиллах болно.

ДАРГА



Б.МӨНХБАТ